

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/201/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он | Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн Захирал: О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1. Хараат бус аудиторын дүгнэлт | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 11 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..... | 11 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 12 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 12 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 13 |
| 4. Аудитын тайлан..... | 15 |
| 4.1 Ерөнхий зүйл | 15 |
| 4.2 Материаллаг байдал | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..... | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 17 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 17 |
| 5. Аудитын илрүүлэлт | 18 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-------------|--|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨХБАУХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.АМАРСАНАА ТАНАА

2024.02.28 № СЭА-2024/201/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 86,7 хувьтай тайлагнагдсан байна.

Хоолны зардал 8,084.4 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 144,372.3 мянган төгрөгөөр, Сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 55,638.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар тус бодлогын баримт бичигт нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус цэцэрлэг нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| /Төгрөгөөр/ | | | |
|-------------|--|--------------------------------|--------------------------------|
| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>71,826,880.90</u> | <u>271,683,279.52</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 21,412,177.08 | 210,964,608.44 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 21,412,177.08 | 210,964,608.44 |
| 3121 | Төгрөг | 21,412,177.08 | 210,964,608.44 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 21,412,177.08 | 210,964,608.44 |
| 33 | АВЛАГА | 2,652.74 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,652.74 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 50,412,051.08 | 60,718,671.08 |
| 351 | Түүхий эд материал | 43,523,101.08 | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 43,523,101.08 | - |
| 354 | Хангамжийн материал | 6,888,950.00 | 60,718,671.08 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,009,250.00 | 58,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 160,000.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 404,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,879,700.00 | 60,096,671.08 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,378,993,532.21</u> | <u>1,336,298,861.97</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,378,993,532.21 | 1,336,298,861.97 |
| 392 | Биет хөрөнгө | 1,294,111,115.89 | 1,251,595,612.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,403,592,874.13 | 1,403,592,874.13 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (199,268,488.80) | (249,085,610.51) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 156,660,282.77 | 178,494,482.77 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (101,899,591.17) | (120,756,152.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 161,138,589.15 | 174,001,115.15 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (136,833,663.06) | (143,432,215.53) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 137,800,953.93 | 138,016,953.93 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (130,792,952.24) | (132,948,946.39) |
| 39217 | Ном | 3,713,111.18 | 3,713,111.18 |
| 393 | Биет бус хөрөнгө | 84,882,416.32 | 84,703,249.77 |
| 39301 | Програм хангамж | 1,750,000.00 | 1,750,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (639,583.68) | (818,750.23) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 83,772,000.00 | 83,772,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,450,820,413.11</u> | <u>1,607,982,141.49</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>619,419.61</u> | <u>5,877,589.61</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 619,419.61 | 5,877,589.61 |
| 413 | Өглөг | 619,419.61 | 5,877,589.61 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 330,275.00 | 5,875,445.00 |
| 4136 | Бусад өглөг | 289,144.61 | 2,144.61 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 287,000.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 2,144.61 | 2,144.61 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,450,200,993.50</u> | <u>1,602,104,551.88</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,450,200,993.50 | 1,602,104,551.88 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 743,888,652.88 | 743,888,652.88 |
| 51101 | Өмч:- төрийн | 743,888,652.88 | 743,888,652.88 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (335,307,256.10) | (183,403,697.72) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,786,265,097.97) | (335,307,256.10) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,450,957,841.87 | 151,903,558.38 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,041,619,596.72 | 1,041,619,596.72 |

| | | | |
|---|--|--------------------------------|--------------------------------|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>1,450,820,413.11</u> | <u>1,607,982,141.49</u> |
|---|--|--------------------------------|--------------------------------|

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,736,392,891.20 | 1,615,399,508.55 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,536,066,398.82 | 50,485,896.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,536,066,398.82 | 50,485,896.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,120,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,120,000.00 | |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ | 1,490,290,497.74 | 28,552,326.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | 44,655,901.08 | 16,956,370.00 |
| 120009 | Бусад орлого | - | 4,977,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,200,326,492.38 | 1,564,913,612.55 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,003,848,500.00 | 1,441,733,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,003,848,500.00 | 1,441,733,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 196,477,992.38 | 123,179,712.55 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 196,477,992.38 | 123,179,712.55 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,285,435,049.33 | 1,463,495,950.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,285,435,049.33 | 1,463,495,950.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,285,435,049.33 | 1,463,495,950.17 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 768,826,810.02 | 955,561,114.09 |
| 210101 | Үндсэн цалин | 596,795,747.21 | 729,064,310.79 |
| 210102 | Нэмэгдэл | 140,260,676.31 | 195,502,021.95 |
| 210104 | Урамшуулал | 31,770,386.50 | 30,994,781.35 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 100,652,027.84 | 121,118,074.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,468,192.85 | 84,044,906.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,169,528.40 | 9,906,505.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,300,422.69 | 7,700,124.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,489,186.19 | 1,754,757.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,224,697.71 | 17,711,780.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 130,598,163.94 | 114,180,012.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,964,970.94 | 14,545,109.93 |
| 210302 | Түлш, халаалт | 82,398,353.00 | 78,201,242.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 37,234,840.00 | 21,433,660.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,187,800.00 | 11,307,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,549,400.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,087,710.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 3,550,690.00 | 11,307,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 124,231,725.00 | 143,555,425.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,200.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 124,215,525.00 | 143,555,425.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,513,901.00 | 3,654,593.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,513,901.00 | 3,654,593.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,424,621.53 | 114,119,231.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,693,256.00 | 27,410,945.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 664,400.00 | 9,100,890.00 |

| | | | |
|----------|---|--------------------------------|------------------------------|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,066,965.53 | 77,607,396.24 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>1,450,957,841.87</u> | <u>151,903,558.38</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>1,450,957,841.87</u> | <u>151,903,558.38</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|--------------------------------|--------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>1,201,446,492.38</u> | <u>1,569,890,812.55</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,120,000.00 | 4,977,200.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,120,000.00 | 4,977,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,120,000.00 | |
| 120009 | Бусад орлого | - | 4,977,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,200,326,492.38 | 1,564,913,612.55 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,003,848,500.00 | 1,441,733,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,003,848,500.00 | 1,441,733,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 196,477,992.38 | 123,179,712.55 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 196,477,992.38 | 123,179,712.55 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,163,264,315.30</u> | <u>1,373,977,981.19</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,163,264,315.30 | 1,373,977,981.19 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,163,264,315.30 | 1,373,977,981.19 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 771,822,765.62 | 950,223,728.87 |
| 210101 | Үндсэн цалин | 599,964,698.68 | 706,495,405.37 |
| 210102 | Нэмэгдэл | 140,462,850.44 | 211,723,489.74 |
| 210104 | Урамшуулал | 31,395,216.50 | 32,004,833.76 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,800,428.74 | 121,115,606.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,092,728.56 | 84,353,688.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,828,971.20 | 9,953,567.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,198,837.30 | 7,589,724.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,497,150.79 | 2,026,574.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,182,740.89 | 17,192,051.97 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 130,598,163.94 | 114,180,012.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,964,970.94 | 14,545,109.93 |
| 210302 | Түлш, халаалт | 82,398,353.00 | 78,201,242.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 37,234,840.00 | 21,433,660.00 |
| 2105 | Нормативт зардал | 123,826,150.00 | 143,751,455.00 |
| 210502 | Хоол, хүнс | 123,826,150.00 | 143,751,455.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,280,000.00 | 8,999,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,280,000.00 | 8,999,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,514,661.00 | 2,611,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,514,661.00 | 2,611,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,422,146.00 | 33,096,478.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,562,146.00 | 25,263,578.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,860,000.00 | 7,832,900.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>38,182,177.08</u> | <u>195,912,831.36</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 16,770,000.00 | 6,360,400.00 |

| | | | |
|--------|--|------------------------|-----------------------|
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 16,770,000.00 | 6,360,400.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 16,770,000.00 | 6,360,400.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 7,120,000.00 | 6,144,400.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 9,650,000.00 | 216,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (16,770,000.00) | (6,360,400.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 21,412,177.08 | 189,552,431.36 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 21,412,177.08 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 21,412,177.08 | 210,964,608.44 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|--------------------|---|
| 1 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 743,888,652.88 | 1,041,619,596.72 | (1,786,265,097.97) | (756,848.37) |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 743,888,652.88 | 1,041,619,596.72 | (1,786,265,097.97) | (756,848.37) |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,450,957,841.87 | 1,450,957,841.87 |
| 8 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 743,888,652.88 | 1,041,619,596.72 | (335,307,256.10) | 1,450,200,993.50 |
| 9 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 743,888,652.88 | 1,041,619,596.72 | (335,307,256.10) | 1,450,200,993.50 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 11 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 743,888,652.88 | 1,041,619,596.72 | (335,307,256.10) | 1,450,200,993.50 |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| 13 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 15 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| 16 | Тайлант үеийн үр дүн | - | - | 151,903,558.38 | 151,903,558.38 |
| 17 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 743,888,652.88 | 1,041,619,596.72 | (183,403,697.72) | 1,602,104,551.88 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---------------|---|------------------|------------------|----------------|-------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,591,303,012.55 | 1,380,338,381.19 | 210,964,631.36 | 86.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,591,303,012.55 | 1,380,338,381.19 | 210,964,631.36 | 86.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,591,303,012.55 | 1,380,338,381.19 | 210,964,631.36 | 86.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,129,332,000.00 | 950,223,728.87 | 179,108,271.13 | 84.1 |
| 210101 | Үндсэн цалин | 761,176,900.00 | 706,495,405.37 | 54,681,494.63 | 92.8 |
| 210102 | Нэмэгдэл | 334,633,900.00 | 211,723,489.74 | 122,910,410.26 | 63.3 |
| 210104 | Урамшуулал | 33,521,200.00 | 32,004,833.76 | 1,516,366.24 | 95.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 141,166,800.00 | 121,115,606.77 | 20,051,193.23 | 85.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 95,993,200.00 | 84,353,688.77 | 11,639,511.23 | 87.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,293,400.00 | 9,953,567.27 | 1,339,832.73 | 88.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,034,700.00 | 7,589,724.42 | 1,444,975.58 | 84.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,258,600.00 | 2,026,574.34 | 232,025.66 | 89.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,586,900.00 | 17,192,051.97 | 5,394,848.03 | 76.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 114,180,012.55 | 114,180,012.55 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,545,109.93 | 14,545,109.93 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 78,201,242.62 | 78,201,242.62 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,433,660.00 | 21,433,660.00 | - | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 151,835,900.00 | 143,751,455.00 | 8,084,445.00 | 94.7 |
| 210502 | Хоол, хүнс | 151,835,900.00 | 143,751,455.00 | 8,084,445.00 | 94.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,999,700.00 | 8,999,700.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 8,999,700.00 | 8,999,700.00 | - | 100. |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,611,000.00 | 2,611,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,611,000.00 | 2,611,000.00 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,177,600.00 | 39,456,878.00 | 3,720,722.00 | 91.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,344,700.00 | 31,623,978.00 | 3,720,722.00 | 89.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,832,900.00 | 7,832,900.00 | - | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,591,303,012.55 | 1,569,890,812.55 | 21,412,200.00 | 98.7 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,441,733,900.00 | 1,441,733,900.00 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,441,733,900.00 | 1,441,733,900.00 | - | 100.0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 123,179,712.55 | 123,179,712.55 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 123,179,712.55 | 123,179,712.55 | - | 100. |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 26,389,400.00 | 4,977,200.00 | 21,412,200.00 | 18.9 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,977,200.00 | 4,977,200.00 | - | 100.0 |

| | | | | | |
|-----------|---|---------------|----------------|------------------|-------|
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 21,412,200.00 | - | 21,412,200.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 21,412,177.08 | (21,412,177.08) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 210,964,608.44 | (210,964,608.44) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 65.00 | 65.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 40.00 | 40.00 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 24.00 | 24.00 | - | 100.0 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 400.00 | 350.00 | - | 87.5 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 3.00 | 3.00 | | |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 42.00 | 42.00 | - | 100.0 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 22.00 | 22.00 | - | 100.0 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь “Хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад хамтран ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх,
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах,
- Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлж тэргүүлэх багшийн манлайлал, үүрэг оролцоог нэмэгдүүлэх,
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээг эв зөийг эрхэмлэж мөрдөж сахилга хариуцлагыг чандлан сахиж идэвх санаачилгатай бүтээлчээр ажиллах ,
- Хүүхэд бүрийн сурч хөгжих , төлөвшихөд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
 1. *"ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",*
 2. *"Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй

боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 157,161.7 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 21,412.18 | 210,964.61 | 189,552.43 |
| Авлага | 2.65 | - | (2.65) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 50,412.05 | 60,718.67 | 10,306.62 |

| | | | |
|---|---------------------|---------------------|-------------------|
| Үндсэн хөрөнгө | 1,378,993.53 | 1,336,298.86 | (42,694.67) |
| Нийт хөрөнгө | 1,450,820.41 | 1,607,982.14 | 157,161.73 |
| Өр төлбөр | 619.42 | 5,877.59 | 5,258.17 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,450,200.99 | 1,602,104.55 | 151,903.56 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,450,820.41 | 1,607,982.14 | 157,161.73 |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 189,552.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 60,718.7 мянган төгрөг болж 10,306.6 мянган төгрөгөөр өссөн нь эцэг эхчүүдийн хандив 12403.5 мянган төгрөг, БШУЯ-аас 592.0 мянган төгрөг, аймгийн БШУГ-аас 3960.9 мянган төгрөгийн хөрөнгө нийт 16,956.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,336,298.9 мянган төгрөг болж 42,694.7 мянган төгрөгөөр буурсан нь эцэг эхчүүдийн хандив 1,750.0 мянган төгрөг, БШУГ-аас 13,654.3 мянган төгрөг, Дээрэт олон улсын энэрлийн байгууллагаас 11,948.0 мянган төгрөг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,200.0 мянган төгрөгийн хөрөнгө нийт 28,552.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан, 77,607.4 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардал байгуулсан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,375,255.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 147,804.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,523,029.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 409,615.0 мянган төгрөгөөр бууруулж 965,640.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 147,804.1 мянган төгрөгөөр тус тус, нийт 1,113,444.2 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар 2023 оны 1,2,6,9,11,12-р саруудад нийт 6 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвийн санхүүжилтийг 502,483.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 1,468,123.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 24,624.4 мянган төгрөгөөр бууруулж 123,179.7 мянган төгрөг, нийт 1,591,303.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,468,123.3 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 123,179.7 мянган төгрөг нийт 1,591,303.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,380,338.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл. 1,380,338.4 мянган төгрөг буюу 86,7 хувьтай байгаа нь хоолны зардал 8,084.4 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 144,372.3 мянган төгрөгөөр, Сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 55,638.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| | | /мянган төгрөгөөр/ | | | |
|--------------------------------|--|--------------------|--------------|------------|----------------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт хувиар |
| Улсын төсвөөс санхүүжих | | | | | |
| 1 | 81605 - Эрүүл мэндийг дэмжих | 3,916.50 | 3,134.00 | 782.50 | 80.0 |
| 2 | 81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 151,835.90 | 143,751.46 | 8,084.45 | 94.7 |
| 3 | 81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 6,144.40 | 6,144.40 | - | 100.0 |
| 4 | 81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 4,888.50 | 2,801.20 | 2,087.30 | 57.3 |
| 5 | 81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 996,836.00 | 852,463.66 | 144,372.34 | 85.5 |
| 6 | 81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 304,502.00 | 248,863.95 | 55,638.05 | 81.7 |
| | Дүн | 1,468,123.30 | 1,257,158.67 | 210,964.63 | 85.6 |
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 123,179.71 | 123,179.71 | - | 100.0 |
| | НИЙТ | 1,591,303.01 | 1,380,338.38 | 210,964.63 | 86.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ 151,835.9 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Тодруулбал хүнсний материалыг Алтан тариа ХХК, Халиун уул ХХК, Сэлэнгэ менежмент ХХК, Өсөх Эрдэнэ сүрэг ХХК, иргэн Далантай, Цэрэнлхам, Мөнхцэцэг нартай тус тус гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг захирал О.Бурмаа хийж, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,285,435.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,854.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 27 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Хагас жилийн санхүүгийн тайлан

Оруулаагүй мэдээллүүд:

- Хандив тусламжийн орлого
- Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу тус цэцэрлэгийн нягтлан бодогч Х.Бат-Эрдэнэд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 151,835.9 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, 48 дугаар зүйлийн 48.5-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр

тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1. *Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг*, 2. *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус цэцэрлэгийн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус цэцэрлэгийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлүүдийг арилгаж, өр төлбөр үүсгэсэн зэрэг зөрчлүүдийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1-т *“...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтын дагуу холбогдох албан тушаалтанд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|----------------|-----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 12,017.2 | 1 | 8,860.7 | 74 |
| Нийт дүн | 1 | 12,017.2 | 1 | 8,860.7 | 74 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус *“бараа үйлчилгээний бусад зардал”* гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит

гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийг 19,800.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолж тайлагнасан алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар:”-ын 4.35 дахь “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Дт. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, Кт. Хуримтлагдсан элэгдэл” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 5,877.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

1. Албан шаардлага

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс хоолны зардлын 5,877.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Х.Бат-Эрдэнэд **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | /мянган төгрөгөөр/ | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|--------------------|--------------|-----|-----|---------|-----|
| | | | | | | | Үүнээс | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | Залруулаагүй | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---------------------------------|----------|-----------------|--|--|----------|-----------------|----------|-----------------|--|--|--|--|
| Элэгдлийн зардлыг дутуу тооцсон | 1 | 19,800.0 | | | 1 | 19,800.0 | 1 | 19,800.0 | | | | |
| Дүн | 1 | 19,800.0 | | | 1 | 19,800.0 | 1 | 19,800.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй | 1 | 5,877.6 | | | 1 | 5,877.6 | | | | | | |
| Дүн | 1 | 5,877.6 | | | 1 | 5,877.6 | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|----------|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. | 1 | | | | 1 | | | | | |
| Дүн | 1 | | | | 1 | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй | 1 | | | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | | | 1 | |
| Нийт дүн | 2 | | | | | | | | 1 | |